

ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨВШИЛ:
ЭЕРЭГ БА СӨРӨГ ҮЗЭГДЛҮҮД

М. Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (ScD), МУИС-ийн тэргүүлэх профессор

Түлхүүр үг: ардчилал, чөлөөт хэвлэл, ил тод байдал, олон ургальч үзэл.

Манай орон ардчилалд хөл тавьж, иргэний нээлттэй нийгмийн эх суурь тавьсанаас хойшхи 15 жилийн хугацаанд хүрсэн томоохон амжилтын нэг бол чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, бие даасан чөлөөт хэвлэл бодит үзэгдэл болсон явдал юм. Хэдийгээр манай оронд чөлөөт хэвлэлийг хөгжүүлж байсан туршлага байгаагүй, чөлөөт хэвлэлийг гардан авч явах бэлэн боловсон хүчин дутмаг байсан боловч өнөөдөр Монгол Улс чөлөөт хэвлэлтэй орон гэдгийг дэлхий дахин хүлээн зөвшөөрсөнийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Энэ үзүүлэлтээрээ социализмын дараах орнуудын дотор тэргүүн эгнээнд явж байна гэж хэлж болно. Ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болсон чөлөөт хэвлэл ардчиллын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд чөлөөт сэтгүүл зүйг ардчилалгүйгээр, ардчиллыг чөлөөт хэвлэлгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Тиймээс ардчиллыг хүндлэн

дээдэлдэг, жинхэнэ чөлөөт хэвлэлтэй орнуудын нэг Германы канцлер асан Герхард Шрёдер "Хэвлэлийн эрх чөлөөгүйгээр ардчилал байж боломгүй. Асуудал нэгэнт үүссэн байвал тэр нь нийтэд ил тод байх ёстой болохоор хуримтлагдаж буй болсон зөрчил, маргааныг хэвлэлийн эрх чөлөөгүйгээр шийдэх аргагүй"¹ гэж хэлсэн нь санамсаргүй хэрэг биш бөгөөд нийгэмд чөлөөт сэтгүүл зүйн үүрэг онцгой чухал гэдгийг онцлон хэлсэн явдал мөн. Тиймээс ч чөлөөт хэвлэлийн үүргийг "дөрөв дэх засаглал", "дөрөв дэх хүчин", "хоточ нохой"-той зүйрлэсэн байдаг.

1990 онд манай оронд олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрч, үүнийг шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсанаас хойш харьцангуй богино хугацаанд чөлөөт сонин хэвлэлийн бүхэл бүтэн сүлжээ бий болж, сэтгүүл зүй ээдрээтэй замыг туулж, саад бэрхшээлтэй цөөнгүй учирч байгаа ч алхам алхамаар урагшилсаар, жам ёсоороо хөгжих чиг хандлагаа олж эхэлж байна. Эхлээд манай сэтгүүл зүйн үйл ажиллагаанд ажиглагдаж буй эерэг үзэгдлүүдийн

талаар товч өгүүлье. Өнөөдөр ОНМХ-ийн тоо 2000 хол давж, мэдээллийн томоохон сүлжээ бий болсноор мэдээллийн шуурхай, хүртээмжтэй байдал мэдэгдэхүйц дээшилсэн. Найман сонин өдөр тутам гарч, 5 телевиз үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацаж, төв орон нутагт нийт 44 радио (үүний 34 нь FM радио), 37 телевиз (үүний 15 нь кабелийн телевиз)² үйл ажиллагаа явуулж байгаа нь үүний тод жишээ юм. Иргэд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх боломж нь эрс дээшилж, Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд чөлөөт сэтгүүл зүй чухал үүрэг гүйцэтгэж байна. Үүнийг иргэдийн хэвлэл мэдээллийн газарт янз бүрийн асуудлаар хандах, санал бодлоо илэрхийлэх, нийгмийн тулгамдсан чухал асуудлуудын талаар тодорхой санал дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг хайсан захидлын тоо жилээс жилд нэмэгдэж, үүнд редакцийн газрууд ч ихээхэн анхааралтай хандах болсноор тайлбарлаж болно. Ийм захидал төр ард түмний холбох гүүр, хэвлэл мэдээллийн газарт олон түмнээс өгч буй нийгмийн захиалга, чухал нийтлэл, нэвтрүүлгийн эх сурвалж болж байгаагийн төдийгүй сэтгүүл зүй ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болох замаар хяналтын үүргийг гүйцэтгэхэд үнэлж баршгүй тус болж байна. Энэ бол

хүмүүсийн сэтгүүл зүйд итгэх итгэл нь дээшилж буйн нэг тод илрэл гэж хэлж болно.

ХМХ-үүдийн мэдээлэх, танин мэдүүлэх, харилцааны, хяналтын, зугаацуулах үүргийн ач холбогдол өсөн нэмэгдэж, мэдээллийг шуурхай, хүртээмжтэй, ил тод, олон ургальч үзлийн үүднээс тусгахад гол анхаарлаа хандуулах болов. Манай сэтгүүл зүй

дэлхий дахины чөлөөт сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг, баримтлах зарчмыг өөрийнхөө үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар идэвхтэй алхам хийж, хүлээн авагчдын мэдээллийн хэрэгцээ сонирхолд түлхүү анхаардаг болсныг аль ч мэдээллийн хэрэгслийн нийт-

«
Манай сэтгүүл зүй дэлхий дахины чөлөөт сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг, баримтлах зарчмыг өөрийнхөө үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар идэвхтэй алхам хийж, хүлээн авагчдын мэдээллийн хэрэгцээ сонирхолд түлхүү анхаардаг болсныг аль ч мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогоос амархан ажиглаж болно.

»

лэл, нэвтрүүлгийн бодлогоос амархан ажиглаж болно. Товчоор хэлбэл, манай сэтгүүл зүйн онол, арга зүйн бааз өөрчлөгдөж чөлөөт сэтгүүл зүйн хөгжлийн голдиролд орсон гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Мөн сүүлийн жилүүдэд зарим сонин хэвлэлийн мэдээллийн багтаамж нь дээшилж, сэтгүүлчид товч тодорхой бичих, мэдээ материалыг бэлтгэхдээ "уруугаа харсан пирамид", эрчимт хөдөлгөөний нэгдэл зэрэг Өрнөдийн сэтгүүл зүйд өргөн хэрэглэдэг бүтэц, зохиомжийн арга болон лидийн төрөл, хэлбэрийг боломжийн төвшинд ашиглах болсон нь манай сэтгүүлчдийн ур чадварт гарсан нааштай алхам мөн.

Түүнчлэн ашигтай болон идэвхтэй мэдээллийн тоо ч нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Энэ бол дэлхийн чөлөөт хэвлэлийн практикт түгээмэл ажиглагддаг шинэлэг хандлагууд манай сэтгүүл зүйд идэвхтэй нэвтэрч буйн нэг илрэл юм.

Өнгөрсөн хугацаанд чөлөөт хэвлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар томоохон алхам хийснийг онцлон тэмдэглүүштэй. 1987 онд Хэвлэл хянах газрыг татан буулгаснаар нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад тавих цензурыг халж, 1992 онд Засгийн газрын "Хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргах журам"-ыг өөрчлөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргахыг амар хялбар болгосон нь ХМХ-ийн бие даасан байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэжээ. 1998 онд "Хэвлэл мэдээллийн чөлөөт байдлын тухай" Монгол Улсын хууль батлагдаж, 1999 оны нэгдүгээр сараас мөрдөж эхэлснээр чөлөөт сэтгүүл зүй бодит зүйл болсон юм. Хэдийгээр энэ хууль цөөхөн заалттай, ХМХ-ийн эрх зүйн зохицуулалттай холбоотой олон асуудлыг шийдвэрлэж чадаагүй ч төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад цензур тогтоохыг, тийм хяналт тавих байгууллага байгуулахыг, мөн тийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхийг, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглож, ХМХ-үүд өөрийнхөө нийтлэл, нэвтрүүлгийнхээ төлөө хариуцлага хүлээж байхыг³ хуульчилж өгсөнөөрөө чухал ач холбогдолтой юм. Үүний нэг бодит илрэл бол НҮБ-ын Хүний эрхийн хороо 2000 онд "Иргэний ба улс төрийн эрхийн пактын биелэлтийн тухай" Монгол Улсын Засгийн газрын

илтгэлийг хэлэлцээд гаргасан дүгнэлтдээ "Монгол Улс Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль гаргасныг тус хороо сайшааж байна"⁴ гэж тэмдэглэсэн явдал мөн.

Энэ бүхэн нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн дунд мэдээллийн төлөө өсрөлдөөнийг бий болгож, сонин хэвлэлийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хэлбэр, өнгө үзэмж, бичлэгийн арга барилд ахиц өөрчлөлт гарахад нөлөөлж байна. Үүнийг бидний хүлээн авагчдын дунд удаа дараа явуулсан судалгааны дүн ч баталж байна. 2003 онд "Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санал бодол" төслийн хүрээнд хот, хөдөөгийн 700 хүлээн авагчдын дунд явуулсан социологийн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдагсадын 54 хувь нь (378 хүн) чөлөөт хэвлэлийн эх суурь тавигдсан, 27 хувь нь (188 хүн) чөлөөт хэвлэл нэлээд сайн хөгжиж байна гэж үзсэн бол зөвхөн нэг хувь нь чөлөөт хэвлэл огт байхгүй⁵ гэсэн саналтай байв. Мөн судалгаанд оролцогсдын 10,3 хувь нь манай ХМХ-үүд, сэтгүүлчид нийгэм-улс төрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлж байна, 83,6 хувь нь зарим асуудалд нөлөөлж байна⁶ гэсэн хариулт өгсөн нь нэлээд өндөр үзүүлэлт юм.

Манай сэтгүүл зүйн үйл ажиллагаанд ийм эерэг үзэгдэл, хандлага байгаа боловч чөлөөт хэвлэлийн хөгжилд саад бэрхшээл учруулахуйц төвшинд багагүй сөрөг үзэгдэл оршиж байна.

1990-ээд оны эхээр ХМХ-үүдийн бие даасан байдал бодит үзэгдэл болж, чөлөөт хэвлэлийн эх суурь тавигдсан нь нэг талаар нийгэмд

гарсан өөрчлөлттэй холбоотой жам ёсны үзэгдэл байсан боловч, нөгөө талаар, чөлөөт хэвлэлийн үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн олон зүйлийг маш богино хугацаанд механикаар шахуу оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн хөгжлийн түүхэн дэх хэвлэл мэдээллийн эрх чөлөөг зохицуулж ирсэн Хэвлэл мэдээллийн дөрвөн онолын хоёр дахь нь болох Либертари онол буюу хэвлэл мэдээллийн бүрэн эрх чөлөөний онол манай сэтгүүл зүйн практикт богино хугацаанд маш хүчтэй нэвтэрсэн нь олон сөрөг үр дагавар үүсэхэд нөлөөлсөн юм.

Богино хугацаанд 100 хүрэхгүй ОНМХ-ийн тоо 2000 хол давж, янз бүрийн сэдэв, чиглэлээр төрөлжсөн олон сонин хэвлэл, радио, телевизийн үер бууж, мэргэжлийн бус олон хүн сэтгүүл зүйн салбарт орж ирсэнээр мэргэжлийн сэтгүүл зүй сонирхогчдын сэтгүүл зүй болж хувирсан билээ. Энэ нь нийтлэл, нэвтрүүлгийн бичлэгийн ур чадвар суларч, төрөл зүйлийн ядууралд орж, материалын зөвхөн агуулга төдийгүй хэл найруулга, зөв бичихийн дүрэм, сонин хэвлэлийн өнгө үзэмж, гадаад дүр төрхөд тавих бүх төрлийн хяналт үгүй болоход хүргэсэн. Чөлөөт хэвлэлийн талаарх уран бүтээлчдийн ч, хүлээн авагчдын ч ойлголт хэт нимгэн байсан нь зүгээр нэг чөлөөт хэвлэл биш "туйлын чөлөөт хэвлэл" бий болоход нөлөөлсөн бөгөөд манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бусдыг гүтгэх, доромжлох, ашиг хонжоо хайх, нэр төр алдар хүнд олж авах, хувийн тооцоо бодох, бусдын хувийн амьдрал, дотоод хэрэгт оролцох, хов жив, тулга тойрсон аар саар зүйлээр хөөцөлдөх

хэрэгсэл болон хувирсан юм. Сэтгүүлчид Олон улсын сэтгүүлчдийн холбооноос тунхаглан зарласан "Сэтгүүлчдийн ёс зүйн зарчим"-д тодорхойлсон "Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлч хүний нэн тэргүүний үүрэг мөн", "Чөлөөт хэвлэлийн арван номлол"-д тусгасан "Нийтлэл бичихээс өмнө нарийвчлан судалгаа хийж алдааг засах, тоо баримтын үнэн зөвийг магадлах"⁸ гэсэн заалтуудыг бүдүүлгээр зөрчиж эхэлсэн. Энэ бүхэн нь сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйг алхам тутамдаа зөрчиж, нийгмийн хариуцлагаа умартахад хүргэсэн төдийгүй сэтгүүлчдийн нэр хүнд олон түмний дунд унаж, мэргэжлийн үнэ цэнэ алдагдахад нөлөөлсөн юм. Тиймээс ч сэтгүүл зүй судлаачид "Сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн төвшин эрс доошилсон, сэтгүүлчдийн нэр хүнд хүн алж, хүрээ талсан алуурчныхаас нэг их дээрдэхээргүй болсон, сэтгүүлч бол цорын ганц зэвсэг-үзгээ, цорын ганц өмч-оюунаа худалддаг "биеэ үнэлэгч" болж хувирсан тухай сүүлийн үед нэг бус удаа яригдаж, мэргэжлийн судлаачид төдийгүй, жирийн уншигчид ч үүнийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болжээ"⁹ гэж дуу алдахад хүргэсэн юм. Сэтгүүл зүйд бий болсон ийм гаж үзэгдэл төр засгийн, улс төрийн зүтгэлтнүүдийн төдийгүй олон түмний дургүйцлийг төрүүлж, үүний эсрэг хариу арга хэмжээ авахад нөлөөлсөн бөгөөд сэтгүүлчдийн ажил төрөлд таагүй нөлөө үзүүлэхүйц томоохон сөрөг үр дагавар авч ирсэнийг бид мэднэ. Энэ бол Монгол Улсын Эрүүгийн болон Иргэний хуулийн шинэчилсэн найруулгад сэтгүүлчдийн

үйл ажиллагаатай холбоотой орсон заалтууд юм. Энэ нь бусдыг ор үндэсгүй гүтгэх, доромжлох замаар хор хохирол учирсан тохиолдолд тодорхой хугацаагаар баривчлах, торгох, сэтгүүлчээр ажиллах эрхийг хасах ял шийтгэх заалтууд бөгөөд өнөөдрийн байдлаар хоёр ч эмэгтэй сэтгүүлч Эрүүгийн хуулийн ийм заалтын дагуу ял шийтгүүлсэн байна.

Өнөөдөр сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд болон сэтгүүлчид энэ заалтуудыг өөрчлөх талаар хууль тогтоох байгууллагад, улс төрчдөд удаа дараа санал хүсэлт тавьж, лобби хийж байгаа боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Бодлогогүй, хариуцлагагүй хийсэн үйлдлийн горьгүйд ингэж амсахаас өөр яах билээ. "Долоо хэмжиж, нэг огтол" гэдэг мэргэн үгийн утга учир үүнд орших бус уу.

Манай сэтгүүлчид ХМХ-ийг жам ёсоор нь хөгжүүлэхэд хангалттай эрх зүйн орчин бүрдээгүй байна, төр засгийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалт их байна гэж ярьдаг нь олонтаа сонсогддог. Харин бид ХМХ-ийн эрх зүйн орчин тийм ч муу биш гэж үздэг. Хамгийн гол нь сэтгүүлчид байгаа нөхцөл боломж, эрх чөлөөгөө зөв эдэлж, хариуцлагаа ухамсарлаж, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зохих төвшинд баримталж чадахгүй байна. Чухам үүний улмаас янз бүрийн асуудалд холбогдох, шүүхэд дуудагдах, муу нэр зүүх явдал түгээмэл юм. Мэдээж цаашид сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалсан, төр засгийн мэдээллийг нээлттэй болгох, мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалахад чиглэгдсэн хууль эрх зүйн акт шаардлагатай гэдэг нь ойлгомжтой.

Өнөөдөр хүлээн авагч, сэтгүүл зүй судлаачдын санааг зовоож байгаа хамгийн гол зүйл бол сэтгүүлчдийн ур чадвар, мэргэжлийн соёл дэндүү сул дорой байгаа явдал юм. Ихэнх сонин хэвлэл бичлэгийн нэг л өнгө аяст баригдаж, бичлэгийн цөөхөн хэдэн төрөл, зүйлийн хүрээнд эргэлдэж, сэдвийн хүрээ хэт явцуу улиг болсон хэдэн сэдвийг (улс төрийн хэрүүл маргаан, хүмүүсийн хувийн амьдрал, оддын амьдрал, үнэн худал нь батлагдаагүй хов живийн шинжтэй зүйл г.м.) эргүүлж тойруулж бичдэг, үг үсэг, найруулгын болон баримтын алдаа ихтэй, агуулгын хувьд ч, хэлбэрийн хувьд ч нэг хэв загварт баригдсан байдаг нь бидний нүдэнд ил байна. Хэрэв 90-ээд оноос өмнө "Үнэн" сонин зөв бичихийн дүрмийн үлгэр загвар, эталон болж байсан бол өнөөдөр манай аль ч сонины нэг дугаараас дундажаар 10-аас доошгүй үг үсгийн алдааг төвөггүй олж болно. Тэр ч байтугай томоохон улс орнуудын төрийн тэргүүнүүдийн нэрийг сольж бичсэн, нэртэй улс төрийн зүтгэлтнүүдийн нэрийг буруу бичсэн, зарим баримт мэдээллийг таамаглалаар бичсэн зэргийг нийгэм-улс төрийн чанартай сонинуудаас уншсаныг санаж байна. Энэ бол редакцийн дотоод хяналт хэмээх ойлголт үндсээр нь үгүй болсны шинж юм. Бас сэтгүүлчийн өөрийнхөө бүтээлд тавих шаардлага дэндүү сул байгаагийн илрэл мөн. Анх ХМХ-үүд бие даан үйл ажиллагаа явуулах болж, олон сонин хэвлэл гарч эхэлсэн үед мэргэжлийн бус олон хүн ХМХ-д орж ирсэн нь нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хэлбэр, бичлэгийн ур чадварт хүчтэй нөлөө үзүүлсэн бөгөөд өнөөдөр тэр алдаа дутагдлаас салж

чадахгүй байгаа нь ажиглагддаг. Мэргэжлийн бус хүмүүст сэтгүүл зүйн талаарх анхны мэдэгдэхүүн, төсөөлөл байгаагүйн улмаас бага хэлбэртэй бичлэгийг мэдээ, асуулт хариултын эвлүүлэг бол ярилцлага, өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн бол эргэцүүлэл гэж нэрлээд бичдэг явдал өргөн дэлгэрч, аль ч сонинд энэ 3-4 төрөл голлосоор өнөөдрийг хүрсэн. Тэд өөр бичлэгийн төрөл, зүйл яаж нэрлэгдэж, яаж бичигдэхийг мэдэхгүй учраас арга ч үгүй биз. Нөгөө талаар, чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөө хэмээх ойлголтыг буруу зөрүү ойлгосны улмаас хүссэн бүхнийг бичих, санасан бүхнийг хөндөх, санаанаас зохиож бичих, баримтыг давсалж, хужирлаж бичих явдал газар авсан. Асуудлын нэг талыг барьж туйлшрах болсноос мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж, хүлээн авагчдыг төөрөгдүүлэх, буруу зөрүү ойлголт төрүүлэх болж, сэдвийн хүрээ явцуурснаас мэдээллийн багтаамж, ашигтай, идэвхтэй мэдээлэл багассан. Энэ бүхэн нь захиалагчдын тоо жилээс жилд багасч, уншууртай, чанартай, гэрэлтэй гэгээтэй сонины тоо гарын арван хуруунд багтахад хүргэж байна. Эрдэмтэн зохиолч Л.Түдэв "Сэтгүүлчийн эдийн засгийн ... нэг чухал үзүүлэлт бол сонин сэтгүүл, дэлгэцийн талбай ашиглалт, радио долгионы нягтралыг хэр зэрэг сайжруулснаар тооцогддог.

Сонин сэтгүүлийн талбай буюу хуудсыг маш их нягтарсан тунгаамал зүйлд зориулах ёстой. Мэдээнд багтах зүйлийг найруулал болгон сунгах, эсвэл найрууллаас том мэдээ, сурвалжлага бичих, сул үг, давхардсан үгээр "саваа дүүргэх" зэрэг дутагдал нь эцсийн дүнд сонин сэтгүүлд өөрт нь хохиролтойгоос гадна уншигч олныхоо үнэт цагийг хохируулдаг дам дамдаа ихээхэн хөнөөлтэй юм"¹⁰ гэж онцлон тэмдэглэсэн нь санамсаргүй хэрэг биш юм.

«
*Мэдээллийн үнэ цэнэ, ач холбогдол
улам нэмэгдэж, маш хурдтай
даяарчлагдаж, хүмүүсийн мэдээлэл
хүлээж авах боломж нь
өргөжиж, мэдлэг боловсрол,
соёлын төвшин эрс дээшилж
байгаа өнөө үед мэдээллийн
багтаамж, чанар, ур чадварын
асуудал бүр ч чухал болж байна.*

»

Мэдээллийн үнэ цэнэ, ач холбогдол улам нэмэгдэж, маш хурдтай даяарчлагдаж, хүмүүсийн мэдээлэл хүлээж авах боломж нь өргөжиж, мэдлэг боловсрол, соёлын төвшин эрс дээ-

шилж байгаа өнөө үед мэдээллийн багтаамж, чанар, ур чадварын асуудал бүр ч чухал болж байна. Гэвч манай нийтлэл, нэвтрүүлгийн чанар, ур чадвар хүлээн авагчдын энэхүү байнга өсөн нэмэгдэж буй оюуны хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байгаа нь тодорхой юм. ХМХ-үүд ил, далд хэсэг бүлэг хүмүүс, улс төрийн эвсэл хүчинд үйлчилдэг, тэднийг хамгаалдаг явдал хэт газар авсан нь мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж, асуудлын нэг талыг барьж, туйлшрах явдал энгийн үзэгдэл болжээ. Сэтгүүлчдийн бичсэн бүтээлүүдтэй танилцаж, лекц уншиж, санал бодол солилцож явахад тэдний ерөнхий суурь мэдлэг хэт

нимгэн, аливаа асуудал, үзэгдэл, үйл явдлын мөн чанарт нэвтрэх, мэдрэх чадвар ихээхэн дутмаг байгаа нь ажиглагддаг. Үүний улмаас асуудал дэвшүүлсэн, хурц шүүмжилсэн, баримтад гүнзгий дүн шинжилгээ хийж, шалтгаан үр дагаврыг илрүүлсэн, асуудалд ил тод байдал, олон ургальч үзлийн үүднээс хандсан нийтлэл, нэвтрүүлэг хуруу дарам цөөн байна. Сэтгүүлчдийн бүтээлч, шинэлэг хандлага, идэвхтэй эрэл хайгуул, идэвх санаачлага, хөдөлмөрч чанар, бас мэдлэг дутмаг байна. Нэрт сэтгүүлчийн хэлснээр "Мэдлэг дутах дээр маань чадвар мөхөсдөхөөр байдал улам хүндэрдэг" нь энгийн үзэгдэл болсон юм. Үүний бодит жишээ бол уйтгартай бичлэгийн оронд утгагүй бичлэг өргөн нэвтэрсэн явдал бөгөөд өнөөдөр уншигч, үзэгч зохиогчийн үзэл бодол, хэмжээнээс хэтэрсэн дүгнэлт, таамаглал, сургаал номлол, далд реклам зэргээс залхаж гүйцсэн гэж хэлж болно. Тэгвэл одоо яах вэ? Тооноос чанарт яаж шилжих вэ? Дээрх сөрөг үзэгдлүүдийг бага ч гэсэн багасгах ямар боломж байна вэ? хэмээх асуулт зүй ёсоор тавигдана. Энэ асуултуудад хариулахаас өмнө нэгэн жишээг иш татъя. Одоогоос зуу гаруй жилийн өмнө ардчиллын эх орон Америкт шинэ сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, өргөн олон түмний боловсролгүй доод давхаргынханд зориулсан "шар хэвлэл"-ийн үер буужээ. Массыг байлдан дагуулсан ийм сонин хэвлэлийн тоо геометрийн прогрессээр нэмэгдэж, тэдний эрх чөлөө хэмжээнээс хэтэрч, сэтгүүлчийн нийгмийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг зөрчих явдал энгийн үзэгдэл болсонд ард түмэн, төр засаг, сэтгүүл зүй судлаачид ихээхэн

дургүйцэж, үүнийг янз бүрийн байдалаар эсэргүүцэж байсан түүхтэй юм. Тиймээс 1942 онд Чикагогийн их сургуулийн ерөнхийлөгч, профессор Р.Хатчинсаар ахлуулсан Хэвлэлийн эрх чөлөөний комиссийг байгуулж, тэд АНУ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдалд дүн шинжилгээ хийж, томоохон дүгнэлт, зөвлөмжийг агуулсан "Хариуцлагатай болон чөлөөт хэвлэлийн тухай" (1947 он) алдарт илтгэлээ боловсруулсан нь өнөөдөр дэлхий дахинд түгээмэл хэрэглэж буй сэтгүүл зүйн хариуцлагатай эрх чөлөөний онолыг боловсруулахад хүргэсэн билээ. Энэ онолын гол утга учир нь сэтгүүл зүй чөлөөтэй байх ёстой, гэхдээ эрх чөлөө нь хэмжээ хязгаартай, нийгмийн өмнө хариуцлага хүлээх чадвартай, ёс зүйтэй, соёлтой байх ёстой гэдэгт оршино. Ийм идэвхтэй, санаачлагатай алхмын үр дүнд Америкт ёс зүйтэй, соёлтой, хариуцлагатай сэтгүүл зүй төлөвшсөн гэж сэтгүүл зүй судлаачид үздэг байна.

 нөөдрийн Монголын сэтгүүл зүйн дүр төрх, одоогоос зуун жилийн өмнөх Америкийн сэтгүүл зүйг санагдуулдаг бөгөөд бид бас хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүйг төлөвшүүлэхийн төлөө идэвхтэй алхам хийх цаг болжээ. Бидний бодлоор энэ асуудлыг нааштай шийдвэрлэхийн тулд юуны өмнө дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, энэ оны 3-р сард хуралдсан МСНЭ-ийн II их хурлаар "Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим"-ыг баталж, энэ баримт бичгийг орон даяар мөрдөж эхэлсэн боловч одоохондоо тодорхой үр дүнд

хагдахын хүрээгүй байгаа нь ажиглагддаг. Өмнө нь хэд хэдэн удаа ёс зүйн ийм баримт бичгийг боловсруулж, мөрдүүлэх оролдлого хийж байсан боловч бас л тодорхой амжилтанд хүрч чадаагүй өнгөрсөнийг бид мэднэ. Үүний гол шалтгаан нь ёс зүйн зарчмыг практикт хэрэгжүүлэх, ягштал баримтлахад нөлөөлдөг механизм алга байгаатай холбоотой юм. Тиймээс нэн даруй Барууны орнуудад өргөн дэлгэрсэн Хэвлэлийн консул, эсвэл Сэтгүүлчдийн ёс зүйн зөвлөлийг байгуулах шаардлагатай байна. Ийм байгууллага бий болсноор сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой аливаа маргаан, санал гомдол, зөрчлийг хууль хяналтын байгууллагад очихгүйгээр шийдвэрлэх боломж бүрдэнэ. Нөгөө талаар сэтгүүлчдэд ёс зүйн зарчим хэмээх ойлголтыг мэдрүүлэх, мэргэжлийн хариуцлагаа ухамсарлан ажиллахад нөлөөлөх болно. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд тухайн ОНМХ-д ажилладаг уран бүтээлчдэд зориулсан гарын авлага, заавал баримтлах дүрмийг боловсруулах шаардлага тулгарч байна. Энэ бол дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн байгууллагуудад өргөн дэлгэрсэн туршлага бөгөөд сэтгүүлчийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг байна. Манайд ийм ажлын эхлэлийг МОНЦАМЭ агентлаг тавьж "МОНЦАМЭ-гийн алтан дүрэм", "МОНЦАМЭ-гийн гарын авлага" зэрэг баримт бичгийг боловсруулсан ч өнөөдөр бусад ХМХ-үүдэд өргөн нэвтэрч чадаагүй. Энэ ажилд сэтгүүл зүй судлаачид, туршлагатай менежерүүд, сэтгүүлчдийн хүч боломжийг ашиглах нь чухал юм.

Хоёрдугаарт, сэтгүүлчийн "өөрийн хяналт" болон редакцийн дотоод хяналтыг хүчтэй болгохын хамт шинээр ажилд орж буй сэтгүүлчдэд тавих шаардлагыг өндөржүүлэх шаардлагатай байна. Сэтгүүлчийн бичсэн материалыг үг үсэг, найруулга зүйн хувьд төдийгүй баримт, учир зүйн алдааг маш сайн хянаж, эх сурвалжийн баталгаатай эсэхийг дээд зэргээр нягтлан магадлах нь нийтлэл, нэвтрүүлгийн чанар, үр нөлөөг сайжруулах төдийгүй янз бүрийн асуудалд орооцолдохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах нэг чухал баталгаа болох юм. Өнөөдөр сэтгүүлчийн материалыг дугаар хариуцсан хүн л алдаг оног уншдаг, заримдаа ямар ч хяналтгүй шууд нийтлэгддэг нь янз бүрийн алдаа гарах, сөрөг үр дагавар авчрах гол шалтгаан болж байна.

Ерээд оноос өмнө нэг материалыг 4-5 хүн гар дамжуулан уншдаг тэр хяналтын тогтолцоог бий болгох боломжгүй гэхэд дор хаяж 2-3 хүн хянан найруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гуравдугаарт, хэвлэл мэдээллийн газруудад ажиллаж байгаа сэтгүүлчдийн зөвхөн мэргэжлийн төдийгүй нийгэм-улс төр, эдийн засаг, эрх зүйн ерөнхий суурь мэдлэг нь ихээхэн дутмаг байгааг харгалзан давтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг чиглэсэн зорилготой, системтэй зохион байгуулах шаардлагатай бөгөөд үүнд МХХ, МСНЭ зэрэг сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд онцгой анхаарах хэрэгтэй байна. Мөн сэтгүүлчдийг гадаад орнуудад томилолтоор явуулах, туршлага солилцох ажил зохион байгуулах нь тэдний мэдлэг, дадлага, чадварыг сайжруулах

чухал алхам болно. Сүүлийн жилүүдэд сэтгүүлч бэлтгэх сургуулийн тоо эрс нэмэгдэж, 20 гаруй сургуульд сэтгүүлч бэлтгэж буй нь нэг талаар, дэмжүүштэй сайн хэрэг боловч, нөгөө талаар, сургалтын чанар муу, багшлах боловсон хүчин дутмаг, ном сурах бичгийн хүрэлцээ, материаллаг бааз тааруу зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан төгсөгчид нь ОНМХ-ийн өнөөгийн шаардлагын төвшинд хүрэхгүй байгаа нь нууц биш юм. Тиймээс сэтгүүл зүйн сургалтыг чанаржуулах, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, багш нарыг тусгайлан бэлтгэхийн хамт элсэгчдэд тавигдах шаардлагыг өндөржүүлэх нь чухал юм. Сэтгүүл зүйд үнэхээр сонирхолтой, байгалиас заяасан өчүүхэн боловч авьяастай хүнийг элсүүлэн сургасан нөхцөлд сайн сэтгүүлч тэрж гардгийг бид туршлагаасаа мэднэ. Орьё гэсэн хүн болгоныг элсүүлдэг өнөөгийн практикийг үндсээр нь өөрчлөөгүй нөхцөлд сайн сэтгүүлч гарахгүй гэдгийг хаана хаанаа ухамсарлан ойлгож, энэ асуудалд нэлээд нухацтай хандах цаг болжээ. Ингээгүй нөхцөлд бид хариуцлагатай, ёс зүйтэй, соёлтой сэтгүүл зүйн тухай ярих нь утгагүй юм.

Дөрөвдүгээрт, сэтгүүл зүйн хөгжилд түлхэц өгдөг нэг гол хүчин зүйл бол сэтгүүл зүйн судлал, шүүмжлэл байдаг. Сэтгүүл зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлж, хөгжлийн чиг хандлагад үнэлэлт дүгнэлт өгч, сэтгүүлчдийн бүтээлийн ололт, дутагдлыг нэгтгэн дүгнэж, шүүмжлэлтэй хандах, шүүмжлэлийг шударгаар хүлээн авах сэтгэлгээг төлөвшүүлэхгүйгээр нийтлэл, нэвтрүүлгийн чанар, ур чадварыг сайжруулах, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх боломжгүй юм. Өнөөдөр

сэтгүүл зүйн судлалд ихээхэн ахиц өөрчлөлт гарч, сүүлийн жилд мэргэжлийн ном сурах бичиг, судалгааны бүтээл болон сэтгүүл зүй судлаачдын тоо нэмэгдэж байгаа боловч, сэтгүүл зүйн шүүмжлэлийг хөгжүүлэх, судлаачдын хүчийг нэгтгэж томоохон хэмжээний суурь судалгаа хийж, тэргүүлэх чиглэлүүдийг хамарсан төсөл хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Ялангуяа сэтгүүл зүйн шүүмжлэл зогсонги байдалд байгаа бөгөөд үүнд манай сэтгүүл зүй судлаачдын идэвх санаачлага дутмаг байгаагийн хамт сэтгүүлч, уран бүтээлчдэд шударга шүүмжлэл, оновчтой санал зөвлөмжийг хүлээж авах, өөрийнхөө уран бүтээлд хэрэгжүүлэх, алдаа дутагдлыг засаж залруулах сэтгэлгээ төлөвшөөгүй байгаа нь сөрөг нөлөө үзүүлж байна гэж хэлж болно. Өөрийгөө өмөөрөх, шүүмжлэлийг эсэргүүцэх, судлаачдын эсрэг дайрч давшлах, өш хонзон авах зорилгоор нэр төрийг гутаах оролдлого хийх явдал түгээмэл юм. Давын өмнө үүнийг өөрчлөх хэрэгтэй байна.

Тавдугаарт, чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаараа төлөвшүүлэн хөгжүүлэхэд эрх зүйн таатай орчин ус, агаар шиг хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Өнөөдөр манай оронд чөлөөт хэвлэлийн эрх зүйн таатай орчин хараахан бүрэн төгс бүрдээгүй байна. Үүнийг зөвхөн сэтгүүлчид төдийгүй, хуульчид, сэтгүүл зүй судлаачид ч хүлээн зөвшөөрдөг. Зарим хуулийн заалтуудыг (Эрүүгийн хуулийн 139-р заалт г.м.) эргэж харах, шинэчлэн боловсруулах, сэтгүүлчдийн мэдээлэл авах, шаардлагатай үед мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах эрхийг баталгаажуулах, ХМХ-ийг эрхлэн гаргах зөвшөөрөл авах

механизмыг уян хатан болгох шаардлага тулгарч байна. Мөн чөлөөт хэвлэлийн эдийн засгийн нөхцөл боломжийг сайжруулахад анхаарах нь чухал юм. "Глоб интернейшнл" ТББ-аас явуулсан судалгаанаас үзэхэд 2004 онд манай орны телевизийн станцийн 40 хувь нь, радиогийн 31 хувь нь, сонин хэвлэлийн мөн тийм хувь нь алдагдалд оржээ. Энэ бол ОНМХ-үүдийн эдийн засгийн байдал туйлын хүнд байгаагийн илрэл мөн. Тиймээс ХМХ-үүд татварын хөнгөлт үзүүлэх, гаднаас оруулж ирж байгаа хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, цаас зэрэг материалыг тодорхой хугацаанд гаалийн татвараас чөлөөлөх нь чөлөөт хэвлэлийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх болно.

Ишлэл

- ¹ "Үнэн". 2001. 06.22. № 210.
- ² "Өдрийн сонин". 2005.11.21. № 280.
- ³ 2001. Хэвлэл мэдээлэлтэй холбоотой Монгол улсын хуулиуд. УБ. "Глоб интернейшнл" ТББ. 5-6 дахь тал.
- ⁴ 2000. Монгол дахь хүний эрхийн байдал. УБ. 48 дахь тал.
- ⁵ 2003. Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санал бодол. (Төслийн тайлан). УБ. МУИС. 8 дахь тал.
- ⁶ Мөн тэнд. 18 дахь тал.
- ⁷ 2001. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. УБ. "Глоб интернейшнл" ТББ. 145 дахь тал.
- ⁸ Мөн тэнд. 143 дахь тал.
- ⁹ 2003. Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил (Төслийн тайлан). УБ: МУИС. 17 дахь тал.
- ¹⁰ Т ү д э в Л. 2002. Сэтгүүлчийн эдийн засаг //Бүтээлийн чуулган. ХҮ боть. 285 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. З у л ь к а ф и л ь М., Ч о й с а м б а ч. 2001. Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
2. З у л ь к а ф и л ь М. 1998. Орчин үеийн Монголын сэтгүүл зүй. УБ.
3. 2000. Монгол дахь хүний эрхийн байдал. УБ.
4. 2005. Монголын сэтгүүл зүйн тулгамдсан асуудлууд (Сэтгүүл зүй судлаачдын үндэсний симпозиумын илтгэлүүдийн эмхэтгэл). УБ.
5. 2003. Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил (Төслийн тайлан). УБ. МУИС.
6. С и б е р т Ф. С. и др. 1998. Четыре теории прессы. М.
7. Т ү д э в Л. 2002. Сэтгүүлчийн эдийн засаг //Бүтээлийн чуулган. ХҮ боть. УБ.
8. 2001. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. "Глоб интернейшнл" ТББ. УБ.
9. 2001. Хэвлэл мэдээлэлтэй холбоотой хуулиуд. "Глоб интернейшнл" ТББ. УБ.

Резюме

Статья посвящена проблемам формирования и тенденции развития современной монгольской журналистики. Автор на примере СМИ показывает положительные и отрицательные явления, существующие на практике деятельности журналистики и предлагает пути решения этих проблем. Основными недостатками современной монгольской журналистики являются нарушение журналистов этических норм, узкость тематического диалогизма публикаций, небалансированность информации, нарушение таких принципов журналистики как правдивость, доступность, плюрализм мнений. Автор считает, что эти факторы оказывают отрицательные влияния на развитие демократической, независимой журналистики в Монголии.